



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/214-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Ч.Цэрэннадмид

Утас: 95112689 Цахим хаяг: ts.nadiii@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.2 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал.....	14
3.4. Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	177
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4.2 Албан шаардлага, зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
БСГ	Боловсрол соёлын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ДЗОУБ	Дэлхийн зөн олон улсын байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР СУМЫН
2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
А.АНУУЖИН ТАНАА

2022.02.25 № СЭА-2022/214-НА-СТА-ТӨЛЗ

тантай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,370,651.00	21,754,036.00
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	28,370,651.00	21,754,036.00
354	Хангамжийн материал	28,370,651.00	21,754,036.00
35410	Бичиг хэргийн материал	29,250.00	
35420	Аж ахуйн материал	23,344,050.00	16,994,905.00
35450	Барилгын засварын материал		586,780.00
35460	Хүнсний материал		4,172,351.00
35470	Бусад хангамжийн материал	4,997,351.00	
36	НӨӨЦИЙН БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	866,195,307.76	858,884,339.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	866,195,307.76	858,884,339.44
392	Биет хөрөнгийн дүн	859,155,307.76	851,844,339.44
39201	Барилга байгууламж	880,896,862.00	880,896,862.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(58,726,457.30)	(73,408,071.62)
39205	Машин тоног төхөөрөмж	15,560,002.70	14,635,640.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,055,909.15)	(3,750,456.81)
39207	Тавилга, эд хогшил	14,095,241.36	15,095,241.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,534,629.91)	(6,944,153.99)
39213	Зам гүүрийн байгуулж	26,019,285.00	26,019,285.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(8,944,129.26)	(12,196,539.90)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,810,872.00	11,810,872.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,033,479.68)	(381,988.60)
39217	Ном	67,650.00	67,650.00
393	Биет бус хөрөнгийн дүн	7,040,000.00	7,040,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,040,000.00	7,040,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	894,565,958.76	880,638,375.44
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	240,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	240,000.00	-
413	Дансны өглөг	240,000.00	-
4136	Ажилчидтай холбогдсон өглөг	240,000.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	894,325,958.76	880,638,375.44
51	Засгийн газрын хувь оролцоо	894,325,958.76	880,638,375.44
511	Засгийн газрын оруулсан капитал	7,040,000.00	7,040,000.00
51101	Өмч: -төрийн	7,040,000.00	7,040,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	757,459,538.42	743,771,955.10
51210	Өмнөх үеийн үр дүн	768,625,422.51	757,459,538.42
51220	Тайлант үеийн үр дүн	(11,165,884.09)	(13,687,583.32)
51300	Дахин үнэлгээний зөрүү	129,826,420.34	129,826,420.34
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	894,565,958.76	880,638,375.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	365,153,351.00	343,225,855.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,311,190.00	13,442,946.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,311,190.00	13,442,946.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,311,190.00	13,442,946.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,277,750.00	12,879,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	33,440.00	563,946.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	359,842,161.00	329,782,909.38
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	321,800,700.00	299,537,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүдгээс санхүүжих	321,800,700.00	299,537,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,623,237.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө		1,623,237.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,041,461.00	28,622,672.38
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,041,461.00	28,622,672.38
2	Үйл ажиллагааны зардал	376,319,235.09	356,913,438.70
21	Урсгал зардал	376,319,235.09	356,913,438.70
210	Бараа, үйлчилгээний зардал	359,553,705.32	338,112,179.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	242,828,284.52	228,008,443.00
210101	Үндсэн цалин	182,312,183.76	170,439,151.00
210102	Нэмэгдэл цалин	39,354,371.76	41,339,294.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	16,116,600.00	16,229,998.00
210105	Гэрээтийн цалин	5,045,129.00	
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	32,016,990.71	29,986,544.76
210201	Тэтгэврийн даатгалын	22,571,016.81	21,666,718.02
210202	тэтгэмжийн даатгалын	2,248,545.56	2,205,419.50
210203	ҮОМШӨ-ий даатгалын	1,951,770.44	1,724,013.03
210204	Ажилгүйдлийн даатгалын	475,232.96	393,988.41
210205	ЭМ-ийн даатгалын	4,770,424.94	3,996,405.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,047,661.00	26,572,472.58
210301	Гэрэл цахилгааны зардал	5,097,661.00	5,292,472.58
210302	Түлш, халаалтын зардал	27,690,000.00	18,390,000.00
210303	Цэвэр бохир усны зардал	3,260,000.00	2,890,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,613,600.00	8,750,041.00
210401	Бичиг хэргийн зардал	1,046,300.00	1,152,950.00
210404	Тээвэр шатахуун	283,500.00	220,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн зардал	5,700.00	529,900.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	378,750.00	425,500.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал	215,500.00	176,000.00

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,683,850.00	6,245,191.00
2105	Нормативт зардал	16,664,165.00	16,690,210.00
210502	Хоол, хүнс	16,300,075.00	14,852,910.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	118,240.00	362,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	245,850.00	1,475,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	539,300.00	2,326,900.00
210601	Багаж техник, хэрэгсэл	2,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	24,200.00	
210604	Урсгал засварын зардал	513,100.00	2,326,900.00
2107	Томилолтын зардал	-	58,100.00
210702	Дотоодын томилолт		58,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	2,208,600.00	1,296,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	634,600.00	648,200.00
210802	Аудит баталгаажуулалтын зардал	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,250,000.00	
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	24,635,104.09	24,423,268.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	633,670.00	
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал		33,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,001,434.09	24,389,968.32
213	Урсгал шилжүүлэг	16,765,529.77	18,801,259.04
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,765,529.77	18,801,259.04
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,765,529.77	18,801,259.04
3	Үйл ажиллагааны үр дүн	(11,165,884.09)	(13,687,583.32)
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн		
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
4	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	(11,165,884.09)	(13,687,583.32)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	359,842,161.00	329,782,909.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	359,842,161.00	329,782,909.38
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	321,800,700.00	299,537,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	321,800,700.00	299,537,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,623,237.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,623,237.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,041,461.00	28,622,672.38
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,041,461.00	28,622,672.38
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	358,802,161.00	325,582,909.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	358,802,161.00	325,582,909.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	342,036,631.23	306,781,650.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	242,397,117.16	228,278,550.00
210101	Үндсэн цалин	180,047,561.94	161,068,019.00
210102	Нэмэгдэл	41,187,826.22	51,190,351.00
210104	Урамшуулал	16,116,600.00	
210105	Гэрээт ажлын хөлс	5,045,129.00	16,020,180.00
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,208,158.07	29,956,437.96
210201	Тэтгэврийн даатгалын	22,507,835.44	20,990,072.13
210202	Тэтгэмжийн даатгалын	2,444,539.49	2,390,630.46
210203	ҮОМШӨ-ийн даатгалын	1,955,631.56	1,859,165.29
210204	Ажилгүйдлийн даатгалын	478,824.04	430,477.56
210205	Эрүүл мэндийн даатгалын	4,821,327.54	4,286,092.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,047,661.00	26,572,472.38
210301	Гэрэл цахилгааны зардал	5,097,661.00	5,292,472.38
210302	Түлш, халаалтын зардал	27,690,000.00	18,390,000.00
210303	Цэвэр бохир усны зардал	3,260,000.00	2,890,000.00
2104	Хангамж, бараа материал	2,561,800.00	1,425,700.00
210401	Бичиг хэргийн зардал	61,600.00	106,000.00
210404	Тээвэр шатахуун	283,500.00	220,500.00
210403	Шуудан холбооны зардал, мэдээлэл тех-гийн үйлчилгээ	5,700.00	529,900.00
210404	Ном		41,400.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,100,000.00	396,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,111,000.00	131,900.00
2105	Нормативт зардал	22,706,725.00	15,857,690.00
210501	Эм	39,300.00	36,300.00
210502	Хоол, хүнс	15,773,625.00	15,439,690.00
210503	Нормын хувцас	6,893,800.00	381,700.00
2106	Эд хогшил урсгал засвар	2,293,200.00	2,326,900.00
210604	Урсгал засвар	2,293,200.00	2,326,900.00
2107	Томилолт, зочны зардал	-	58,100.00
210702	Дотоодын томилолт		58,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	2,208,600.00	1,296,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	634,600.00	648,200.00

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,250,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,613,370.00	1,009,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	633,670.00	
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	979,700.00	1,009,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,765,529.77	18,801,259.04
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт	16,765,529.77	18,801,259.04
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,765,529.77	18,801,259.04
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,040,000.00	4,200,000.00
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	1,040,000.00	4,200,000.00
22	Хөрөнгийн зардал	1,040,000.00	4,200,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,040,000.00	4,200,000.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,040,000.00	4,200,000.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,040,000.00)	(4,200,000.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	7,040,000.00	129,826,420.34	768,625,422.51	905,491,842.85
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(11,165,884.09)	(11,165,884.09)
2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	7,040,000.00	129,826,420.34	757,459,538.42	894,325,958.76
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
ҮХ-ийн өсөлт, бууралт			-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(13,687,583.32)	(13,687,583.32)
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	7,040,000.00	129,826,420.34	743,771,955.10	880,638,375.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	337,805,700.00	309,358,413.34	28,447,286.66	91.6
21	Урсгал зардлын дүн	337,805,700.00	309,358,413.34	28,447,286.66	91.6
210	Бараа үйлчилгээний зардал	337,805,700.00	309,358,413.34	28,447,286.66	91.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,512,400.00	226,989,451.00	13,150,529.00	94.4
210101	Үндсэн цалин	173,740,000.00	159,778,920.00	13,961,080.00	92.0
210102	Нэмэгдэл	50,379,800.00	51,190,351.00	(810,551.00)	101.6
210104	Урамшуулал	16,392,600.00	16,020,180.00	372,420.00	97.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,379,800.00	29,795,299.96	1,584,500.04	95.0
210201	Тэтгэврийн даатгал	21,759,400.00	20,880,548.13	878,851.87	96.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,405,100.00	2,377,689.46	27,410.54	98.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,924,100.00	1,851,752.29	72,347.71	96.2
210204	Ажилгүйдлийн даатгал	481,000.00	419,199.56	61,800.44	87.2
210205	ЭМД-ын хураамж+В21	4,810,200.00	4,266,110.52	544,089.48	88.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,218,500.00	26,572,472.38	9,646,027.62	73.4
210301	Гэрэл цахилгааны зардал	6,154,400.00	5,292,472.38	861,927.62	86.0
210302	Түлш, халаалтын зардал	24,664,100.00	18,390,000.00	6,274,100.00	74.6
210303	Цэвэр бохир усны зардал	5,400,000.00	2,890,000.00	2,510,000.00	53.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,328,800.00	1,252,700.00	76,100.00	94.3
210401	Бичиг хэрэг	56,900.00	106,000.00	(49,100.00)	186.3
210402	Тээвэр шатахуун	220,600.00	220,500.00	100.00	100.0
210403	Шуудан холбоо	655,100.00	529,900.00	125,200.00	80.9
210404	Ном	41,400.00	41,400.00	-	100.0
210405	Хог хаягдал	252,400.00	223,000.00	29,400.00	88.4
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	102,400.00	131,900.00	(29,500.00)	128.8
2105	Нормативт зардал	19,151,400.00	15,857,690.00	3,293,710.00	82.8
210501	Эм	36,300.00	36,300.00	-	100.0
210502	Хоол хүнс	18,733,400.00	15,439,690.00	3,293,710.00	82.4
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	381,700.00	381,700.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,526,900.00	6,526,900.00	-	100.0
210601	Багаж хэрэгсэл	3,200,000.00	3,200,000.00	-	100.0
210602	Тавилга	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	2,326,900.00	2,326,900.00	-	
2107	Томилолт, зочны зардал	58,100.00	58,100.00	-	100.0
210702	Дотоод томилолт	58,100.00	58,100.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	1,620,200.00	1,296,200.00	324,000.00	80.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	648,200.00	648,200.00	-	100.0

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	үйлчилгээний төлбөр				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	648,000.00	324,000.00	66.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,009,600.00	1,009,600.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,009,600.00	1,009,600.00	-	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	337,805,700.00	328,159,672.38	9,646,027.62	97.1
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	299,537,000.00	299,537,000.00	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	299,537,000.00	299,537,000.00	-	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,268,700.00	28,622,672.38	9,646,027.62	74.79
132001	Орон нутгийн төсвөөс	38,268,700.00	28,622,672.38	9,646,027.62	74.79
124	Бусад эх үүсвэр			-	
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	
001	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
003	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
	АЖИЛЛАГСДЫН ТОО	21.00	21.00	-	100.0
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00	-	100.0
	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	-	100.0
	Гэрээт ажилтан	3.00	3.00	-	100.0
010	СУРАЛЦАГЧДЫН ТОО /ЖИЛИЙН ДУНДЖААР/	24.00	24.00	-	100.0
015	Төрийн өмчит ЕБС	24.00	24.00	-	100.0
024	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ			-	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	Зөрүү
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		1,623,237.00	(1,623,237.00)
21	Урсгал зардал		1,623,237.00	(1,623,237.00)
210	Бараа ажил үйлчилгээний зардал		1,623,237.00	(1,623,237.00)
2101	Цалин хөлс		1,450,237.00	(1,450,237.00)
210101	Цалин хөлс		1,450,237.00	(1,450,237.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	-	173,000.00	(173,000.00)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	173,000.00	(173,000.00)
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,623,237.00	(1,623,237.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн тайлан		1,623,237.00	(1,623,237.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,623,237.00	(1,623,237.00)

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 2 дугаар цэцэрлэгийн /цаашид Шаамар сумын 2 дугаар цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримт, шилэн данстай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн захирал аудитор Ч.Цэрэннадмид, аудитор Т.Эрдэнэтуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “ЦЭСБ-Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шаамар сумын 2 дугаар цэцэрлэг нь “Хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчинд хүүхэд нэг бүрийн хөгжлийг ахиулсан чадварлаг хамт олон байхыг эрхэмлэнэ.” гэж зорилгоо тодорхойлсон байна.

Шаамар сумын 2 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх,
- Хүүхэд бүрийг хөгжүүлэх эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэхэд эцэг эхийн хамтын ажиллагаа, үүрэг оролцоог нэмэгдүүлэх
- Багш бүр сургалт үйл ажиллагааны бэлтгэлийг чанартай хийж, үр дүнтэй хэрэгжүүлэх,
- Цэцэрлэгийн орчны аюулгүй байдлын стандартыг мөрдөж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.
- БШУ-ны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн А/05, А/10, 1 тоот хамтарсан тушаал "Шалгуур үзүүлэлт шинэчлэх тухай" ур чадвар
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- "Нийгмийн даатгалын тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 32 дугаар зүйлийн 1 дүгээр зүйл-д-НДШ-ийн хувь хэмжээнд өөрчлөлт орсон,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан "Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 376,319.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,762.2

мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,634.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Шаамар сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,927.5 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	28,370.6	21,754.0	(6,616.6)
Үндсэн хөрөнгө	866,195.3	858,884.3	(7,311.0)
Нийт хөрөнгө	894,565.9	880,638.4	(13,927.5)
Өр төлбөр	240.0	-	(240.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	894,325.9	880,638.4	(13,687.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	894,565.9	880,638.4	(13,927.5)

Бараа материалын дансны үлдэгдэл 21,754.0 мянган төгрөг болж 6,616.6 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал, хүнсний материалын үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 955,565.6 мянган төгрөг болж өмнөх оноос 75.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 3,200.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж /принтер, проектор, дэлгэц/, 1,000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, ном худалдан авч, ДЗОУБ-аас 1,860.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж /ус цэвэршүүлэгч/, үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Шаамар сумын ИТХ-ын 40 дүгээр тогтоолоор 5,984.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж акталж данс бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 880,638.4 мянган төгрөг болж 13,687.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 343,225.8 мянган төгрөг болж өмнөх оноос 21,927.5 мянган төгрөгөөр буюу 6 хувиар буурсан байна. Энэ нь тусгай зориулалтын санхүүжилт өссөнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 356,913.4 мянган төгрөг болж өмнөх оноос 19,405.8 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар буурсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Шаамар сумын 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 372,392.1 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 34,586.4 мянган төгрөгөөр нэмж, 337,805.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр **337,805.7** мянган төгрөгийн төсөв баталснаас 299,537.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 38,268.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 299,537.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 28,622.7 мянган төгрөг нийт 328,159.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **309,358.4** мянган төгрөгийг зарцуулж, 18,801.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 328,159.7 мянган төгрөг буюу 91.6 хувьтай тайлагнагдсан байгаа нь цалин, НДШ-ийн зардал 14,735.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал 9,646.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 76.1 мянган төгрөгөөр, нормативт зардал 3,293.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 324.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас ариутгал, халдваргүйжүүлэлтийн зардалд 173.0 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс 1,450.2 мянган төгрөгийн санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай ” тушаалын нэгдүгээр хавсралт “*Короновируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам*”-ын дагуу

сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 115 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 33 мэдээллийг хугацаа хоцроон, 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Шаамар сумын 2 дугаар цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаанд 337,805.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 309,358.4 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.6 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 650.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 1 зөвлөмж өгснөөс албан шаардлагыг биелүүлж, зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
----------	---------------------	---------	-------------------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	650.4	2	650.4	100
Зөвлөмж	1				
Нийт дүн	2	650.4	2	650.4	50

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 17,079.0 мянган төгрөгөөр шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,901.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 154.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2,747.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.1 Төлбөрийн акт

4.1.1 Эрхлэгч А.Анужинд ур чадварын нэмэгдлийг тогтоосон хувь хэмжээнээс илүү тооцож, 154.1 мянган төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, Шаамар сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн захирамж “*Эрхлэгч А.Анужин 25 хувь*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 2,747.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Түшиг сумын 1 дүгээр цэцэрлэг	2	2,901.4	-	-	1	154.1			1	2,747.3